Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.НЯМДАВААГИЙН 2025 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин /сүүлийн хагас жилд/ | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон шинээр батлагдсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийг байгууллага, албан хаагч, иргэдэд сурталчилан таниулах, сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ-1.1** Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, бусад шийдвэрийг хяналтад авах бүртгэлжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлт үр дүнг тооцох тайлагнах | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжитийн хувь | 96 хувь | 96 хувь | Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг тухай бүр хяналтад авч ажиллалаа.<br>2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль 9, Монгол Улсын Их Хурлын тогтоол 9, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 18, Ерөнхийлөгчийн зарлиг 7, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл 5, Засгийн газрын тогтоол 84, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 62, Засгийн газрын албан даалгавар 5-ийг тус тус хяналтад авч, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж байна. | 06:05<br>12:01 | |
| 2 | **Арга хэмжээ-1.2** Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2025 оны нэгдсэн төлөвлөгөө | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90.0 хувь | 65 хувь | Эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааг олон нийтийн цахим | 06:05<br>12:01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | хэрэгслээр иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>Энэ оны сүүлийн хагас жилийн байдлаар холбогдох албан хаагчидтай хамтран 9 удаагийн подкастыг бэлтгэн "Хархорин мэдээ" цахим хуудсаар.иргэдэд хүргэсэн нь нийт 47.4 мянган удаагийн хандалт, 2 удаагийн рийл бэлтгэн иргэдэд хүргэсэн нь 17.9 мянган удаагийн хандалтыг тус тус авсан байна.<br>Төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 96 хувийн биелэлттэй байна. | | |
| 3 | **Арга хэмжээ-1.3**<br>Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | 2025 оны хамаарал бүхий зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан. | 06:05<br>12:01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг тооцож холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан эсэх | | | | | |
| 4 | **Арга хэмжээ-1.4** Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалын эрх зүйн үндэслэлийг хангуулах | Гарсан захирамж, тушаалын тоогоор | 326<br>26 | Захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянасан байна. | Энэ оны сүүлийн хагас жилийн байдлаар Засаг даргын 131 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 18 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж гаргуулсан. | 06:05<br>12:01 | |
| 5 | **Арга хэмжээ-1.5** Холбогдох тайлан мэдээг нэгтгэн дүгнэж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнах | Сумын сар бүрийн ажлын тайлан, хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, хууль зүйн туслалцааны талаарх мэдээлэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт, үндэсний болон дэд хөтөлбөрийн | Тайланг холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан. | Тайланг хугацаанд нь нэгтгэн дүгнэж, холбогдох газарт тайлагнасан байна. | Сумын ажлын тайланг сар бүр, эрх зүйн сургалт сурталчилгааны тайланг сар бүр, хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, хууль зүйн туслалцааны талаарх мэдээлллийг улирал бүр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тус тус нэгтгэн гаргаж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан. | 06:05<br>12:01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэж, холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан эсэх | | | | | |
| 6 | **Арга хэмжээ-1.6**<br>Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулах | -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90.0 хувь | 60 хувь | Дотоод хяналт шалгалтын нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу сүүлийна хагас жилд 4 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан.<br>Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн талаар албан хаагчдаас санал асуулга авч дүгнэлээ. | 06:05<br>12:01 | |
| 7 | **Арга хэмжээ-1.7**<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо<br><br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ийн хэрэгжилтийн хувь | 2<br><br>. | 3<br><br>60.0 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дагаж гарсан журмаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, 21 албан хаагч хамрагдсан.<br>Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын 44 албан хаагчийг хамруулан эрсдлийн үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон 11 албан хаагчаар ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулан бүртгэлээ. Албан хаагчдын өдөр тутмын харилцааг сайжруулах, байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор "Та дараагийн хүндээ юу өгөх вэ?" хөгжөөнт видео, "Өглөө бүр цагтаа ирцгээе, дүүрэн инээмсэглэлээр өдрөө угтъя!" мотивацын видео хийж, байгууллагын | 06:05<br>12:01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | фэйсбүүк группт байршуулсан нь албан хаагчдын дунд эерэг сэтгэлзүй, хүндлэл, цагийн сахилга бат сайжрахад тодорхой үр нөлөө үзүүллээ.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хэрэгжилтийн хувь эхний хагас жилийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна. | | |
| **Зорилт 2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ-2.1**<br>Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах | -Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал | 43 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулсан. | 1.1.Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ыг мөрдөж ажиллана. | Хүний нөөцийн мэдээллийн системд бүртгэлтэй 44 албан хаагчийн мэдээллийг бүрэн шинэчилж, өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, зөрчилгүй ажиллаж байна.<br>Сүүлийн хагас жилд 43 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг нэг бүрчлэн системд оруулж, төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авсан. | 06:05<br>12:01 | |
| **Зорилт 3. Сангийн сайдын баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажилалгааны журам"-ын хэрэгжилтийг хангаж, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д мэдээллийг цаг тухайд нь байршуулах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1**<br>**Арга хэмжээ 3.1**<br>ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувиар | - | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувь өссөн байна. | ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 16 төсөл, хөтөлбөрийн мэдээллийг бүрэн оруулсан. | 06:05<br>12:01 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг цаг тухайд нь байршуулах | | | | Мөн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2026 онд хийгдэх ажлыг эрэмбэлэх ажлыг зохион байгуулж, ажлын хэсгийн эрэмбийг системд бүрэн орууллаа. | | |
| **Зорилт 4. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн хөтлөлтийг хариуцаж, үнэлгээний хорооны гишүүдийг арга зүйгээр хангаж, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 4.1** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, үр дүнг тухай бүр системд оруулж, ил тод мэдээлэх | Төсөл, арга хэмжээний тоогоор | 16 | Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжих 9 төсөл арга хэмжээний тендерийг цахимаар зарлаж, үр дүнг хугацаанд нь нийтэлж ажилласан. Гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулах гэрээг хугацаанд нь боловсруулж, гэрээг баталгаажуулан ажиллалаа. | 06:05<br>12:01 | |

**НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ**

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Хархорин мэдээ" фэйсбүүк хуудсыг хөтлөх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | Мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол хүргэж ажиллах | Хархорин мэдээ фэсэбүүк хуудсанд суманд болж буй үйл явдлын мэдээ, мэдээлэл, зарлал, цаг агаарын мэдээ, анхааруулга, сэрэмжлүүлгийг тухай бүр нийтэлж, иргэдэд хүргэж ажилласан. | | |
| | Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний сүүлийн хагас жилийн биелэлтийг тайлагнах | Биелэлтийг хугацаанд нь нэгтгэн тайлагнасан байна. | | Хугацаандаа тайлагнасан эсэх | Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, сүүлийн хагас жилийн тайланг холбогдох албан хаагчдаар гаргуулан биелэлтийг нэгтгэж байна. | | |
| | Сумын Засаг даргын ажиллагааны хөтөлбөрийг | Төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг | | Боловсруулж батлуулсан эсэх | Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг боловсруулах | боловсруулж батлуулсан байна. | | | боловсруулж Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. | | |
| | Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | Даалгасан үүрэг, даалгаврыг бүрэн биелүүлсэн эсэх | Сүүлийн хагас жилд сумын Засаг даргын захирамжаар байгуулсан 5 үнэлгээний хорооны дарга, гишүүн, Засаг даргын захирамжаар байгуулсан 1 ажлын хэсгийн гишүүн, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан 1 ажлын хэсэгт тус тус ажиллаж үүрэг гүйцэтгэлээ. | | |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин (Эхний хагас жил) | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.<br>Төрийн албан хаагчдын цахим сургалтын платформ дахь сургалтуудад хамрагдах | Сургалтад хамрагдаж авсан сертификатын тоо | 2 | 2 | Удирдлагын академийн төрийн албан хаагчийн сургалтын нэгдсэн платформд байршуулсан “Албан бичиг солилцооны дундын систем /Docx/”, цахим ур чадварыг дээшлүүлэх “Мэдээллийн хүртээмж” сургалтад тус тус хамрагдаж, гэрчилгээ авсан. | 06:05<br>12:01 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ........................ / Н.НЯМДАВАА/ 2025.12.03
*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*